

平成 30 年度 研究成果報告書  
Research Achievement Report FY2018

講座名・職名 Course Title・Job Title	アジア I 講座・特任准教授
氏名 Name	Magsarjav Bayarsaikhan
専門分野 Academic Field	Linguistics

主たる研究テーマ Principal Research Subject	1. Монгол хэлний дагавар, 2. Манж монгол харьцуулсан хэлшинжлэл
<p>1. Төлөвлөсөн ёсоор монгол хэлний үүсмэл үгийн жагсаалтын бүртгэл гаргах ажил үндсэндээ дууссан боловч, сурвалж, бичиг, ном зохиолоос болон нийгэмд шинээр гарч ирж буй үгсийг санд бүртгэн баяжуулалт хийж байна. Мөн 2018 онд монгол хэлний нэр үг ба үйл үг бүтээх нийт 100 гаруй дагаврын тодорхойлолт тайлбарыг анхны хувилбараар гаргав. Үүнд цөөнгүй дагаврын тайлбарыг өмнөх судлаачдаас өөрөөр авч үзсэн зүйл бий. Энэ судалгааны хэрэглэгдэхүүнд нэмэр болгож хэлний дурсгалуудын баримтыг цуглуулах ажил үргэлжилж байна.</p> <p>2. Шинээр олдсон манж-хятад-монгол-ойрд 4 хэлний толь бичгийг хамтран хэвлүүлэхэд бэлтгэж дуусав. Үүнд, миний бие уг дурсгалыг сурвалж судлалын талаас анхдагч судалгааг хийж, тус толийн онцлог, бусад тольтой холбогдох харьцаа хамаарал, толь бичгийг зохиоход ашигласан эх сурвалжийг тодруулах, он цаг болон зохиогчийг тодруулах зэрэг үндсэн асуудлыг хөндсөн судалгааны оршил өгүүлэл А4: 23 тал хэмжээтэй бичиж бэлэн болгоод хамтрагч Унгар улсын эрдэмтдэд илгээгээд байна. Мөн энэ толийн монгол, тод бичгийн болон ойрд аялгууны дуудлага тэмдэглэсэн манж бичгийн эрдэм шинжилгээний галигийг хянаж редакторласан. Энэ бүтээл удахгүй хэвлэгдэх болно.</p> <p>3. БНСУ, Монголын судлаачид хамтран хийж, хэвлүүлэх гэж буй Гэсэрийн туужийн судалгааны ажлын хүрээнд Бээжин барын Гэсэрийн туужийн монгол бичгийн галигийг хянаж редакторлан засвар хийж хүлэллэгэн өглөө. Энэ ажил 2019 онд хэвлэгдэнэ.</p> <p>4. Урьд нь Өвөр Монголын Их Сургуулийн багш нартай хамтран Өвөр монголын оюутнуудад зориулан бичээд байсан “Кирилл монгол бичгийн сурах бичиг”-ийг энэ онд эцсийн хяналтыг хийв. Энэ ном 2018 оны намар хэвлэгдэж гараад одоо сургалтанд хэрэглэгдэж эхлээд байна.</p>	